



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч
хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30, 39, 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 01 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын 01, 02, 03, 04 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн онцгой комиссын 01 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/191 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр гаргасан Нийслэлийн Засаг даргын захирамжийн 1 дүгээр хавсралт болох “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийг удирдлага болгон байгууллагын хэмжээнд зохион байгуулах ажлыг нэгдүгээр хавсралтаар, байгууллагын ажлыг тусгай горимд шилжүүлэн, хариуцлагатай жижүүрээр ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай зардлыг төсвийн зохицуулалтаар шийдвэрлэхийг нягтлан бодогч Ц. Бямбасүрэнд зөвшөөрсүгэй.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах мэргэжилтэн Н.Пүрэвсүрэнд даалгасугай.

ДАРГА



С.БАТЖАРГАЛ

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл,
технологийн парк” ОНӨТҮГ-аарын даргын 2020
оны 02 сарын 12 өдрийн 110 тоот тушаалын
1 дүгээр хавсралт



ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Нэг. Зорилго

Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Улсын болон нийслэлийн байгууллага, байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зөв төлөвлөх, ажилтан албан хаагчид, хүн амыг урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад чиглэгдэнэ.

Хоёр. Удирдлага болгон хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичиг

2.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 102 дугаар сарын 12-ны өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10 дугаар зарлиг,

2.2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Бэлэн байдлын зэрэг шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол,

2.3. Улсын онцгой комиссын 2020 оны 01 дүгээр тогтоол, 1, 2, 3, 4 дүгээр хурлын шийдвэр,

2.4. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах тухай” 19 дүгээр албан даалгавар

2.5. Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/166, “Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/191 дүгээр захирамж, Нийслэлийн онцгой комиссын 02, 03 дугаар хурлын шийдвэр, Ажлын хэсгийн 01 дүгээр хурлын шийдвэр.

Гурав. Зохион байгуулалтын арга хэмжээ

3.1 Гамшгаас хамгаалах болон ажлын тусгай горимоор ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллах

3.2 Нөхцөл байдлын талаар болон дээд байгууллага, албан тушаалтны шийдвэр, холбогдох мэдээллийг ажилтан албан хаагч нарт тухай бүр мэдээлэх

3.3 Улсын болон орон нутгийн онцгой комиссын өгсөн үүрэг чиглэл, удирдамжийг хэрэгжүүлж ажиллах

3.4 Онцгой шаардлагатай үед байгууллагын үйл ажиллагааг хэсэгчлэн буюу түр хугацаагаар зогсоох, хязгаарлах

3.5 Байгууллагын албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сахиулах, ажил амралтын хуваарийг зохицуулж эрүүл мэндэд нь анхаарах, шаардлагатай тохиолдолд богиносгосон цагаар ажиллуулах

3.6 Байгууллагын бэлэн байдлыг хангаж, хариуцлагатай эргүүл жижүүр томилон хуваарийн дагуу ажиллуулах

3.7 Байгууллагын өрөө тасалгаа, гал тогоо, албан хаагчдын түр амрах өрөөний ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийлгэх ажлыг зохион байгуулалтаар хангах, хяналт тавьж тайлагнан ажиллах

3.8 Холбоо зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулах, шаардлагатай үед машин техникийн бэлэн байдлыг хангах, гэрээт харуул хамгаалалтыг өндөржүүлсэн бэлэн байдлыг хангуулах удирдлага зохион байгуулалтанд хяналт тавих

3.9 Ажиллагсадын автобусын цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих


3.10 Гаднаас ирж буй иргэнд зохих шаардлага тавих, ариутгал хийж оруулахад анхаарах

3.11 Авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар нийслэл, дүүргийн Онцгой комисс болон холбогдох дээд байгууллага, албан тушаалтанд тухай бүр танилцуулж байх

Дөрөв. Үйл ажиллагааны зардал

Коронавирусын халдварын болзошгүй тохиолдлын үед шуурхай хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны зардлыг өөрийн төсвийн зохицуулалтаар шийдвэрлэн ажиллах.

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-азрын даргын 2020 оны 12 сарын 18-ны өдрийн 1/10 тоот тушаалын 2 дугаар хавсралт



ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРЭЭР АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Ажилтны нэрс	Албан тушаал	Хариуцлагатай жижүүр хийх өдөр
1	С.Батжаргал	Дарга	02.19
2	Н.Пүрэвсүрэн	Ахлах мэргэжилтэн	02.20
3	Ц.Бямбасүрэн	Нягтлан бодогч	02.21
4	Д.Номин-Эрдэнэ	Захиргааны ажилтан	02.25
5	Г.Пүрэвдорж	Инженер	02.23
6	Б.Батбилэг	Бүтээн байгуулалтын мэргэжилтэн	02.26
7	Н.Гантулга	Төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн	02.27
8	Х.Бямбаа	Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн	02.28
9	Н.Энгүүн	Маркетинг, ОНХХ хариуцсан мэргэжилтэн	02.29
10	О.Чулуун-Эрдэнэ	Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	02.24
11	Э.Ундармаа	Нярав	02.22
12	О.Зоригт	Жолооч	03.01
13	С.Гульнар	Үйлчлэгч	03.02

Жич: Сар шинийн баяр, амралтын өдрүүдээр ажиллах хариуцлагатай жижүүрүүд ажлын байранд ирж хамгаалалтын ажилтаны бүртгэлийн дэвтэрт тухайн цаг үеийн нөхцөл байдлын талаар тэмдэглэл хөтөлнө.